



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН Ш.РАДНААСЭД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,  
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,  
И-мэйл: mofa@mofa.gov.mn, Вэбсайт: www.mofa.gov.mn

2019.05.07 № 01/1775  
танай 2019.04.12 ны № 10 Т

Асуулгын хариу

Таниас 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 10 дугаартай албан бичгээр ирүүлсэн асуулгын хариуг хүргүүлж байна.

1. Ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай, тогтвортой орчныг бүрдүүлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ:

Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн 2.1.10-д “Ноолуур” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заасныг үндэслэн Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор “Ноолуур” хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. “Ноолуур” хөтөлбөрийн 2018 оны эцсийн тайланг хавсралтаар хүргүүлэв.

Монгол банк, Монгол Улсын Хөгжлийн банктай хамтран ажиллаж, “Ноолуур” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2018 онд 200 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг бүрдүүлсэн ба Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Монгол улсын Хөгжлийн банкны хооронд 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 180313/06-070 дугаар бүхий “Ноолуур хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий нөхцөл тохирох гэрээ”-г байгуулан, ноолуурын үйлдвэрлэл эрхлэгч 20 аж ахуйн нэгжид нийт 194.4 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосон байна. Одоогийн байдлаар 71.7 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдсэн ба олгосон зээлүүд бүгд хэвийн ангилалд байна.

“Ноолуур” хөтөлбөрт “угаасан ноолуурын экспортыг багасгах чиглэлээр тарифын болон тарифын бус хязгаарлалт хийх асуудлыг судлан шийдвэрлэх” гэж заасан. Энэ ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч, ажиллаж байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн биржийн шимтгэл ноолуурын боловсруулалтын түвшнээс хамаарахгүйгээр 0.32 хувь байсныг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-тай хамтран ажиллаж, тус биржийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 05-р сарын 31-ны өдрийн 04 тоот тогтоолоор угаасан ноолуурт 1 хувь болгон нэмэгдүүлж, самнасан ноолуурт 0.2 хувь болгон бууруулж бодлогын зохицуулалтыг хийсэн. Үүний үр дүнд 2018 онд угаасан ноолуурын экспорт өмнөх онтой харьцуулахад 2.3 хувиар буурч, самнасан ноолуурын экспорт 8.45 хувиар, бэлэн бүтээгдэхүүний экспорт 8.5 хувиар тус тус өссөн байна.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн А-40 тоот тушаалаар Ноолууран түүхий эдийг боловсруулж нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай эрхзүйн орчин бүрдүүлэх, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд Гадаад харилцааны

00000725

яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй зохих уулзалтуудыг зохион байгуулж Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль болон бусад эрхзүйн зохицуулалтуудыг судалж холбогдох тооцооллыг боловсруулан ажиллаж байна. Манай улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэж орохдоо ноолуурын экспортын татварыг 10 жилийн хугацаанд шат дараатайгаар бууруулж, тэглэх үүрэг хүлээсэн ба 2007 онд хугацаа нь дуусахад нэг удаа 2012 он хүртэл сунгасан байдаг. Ингэснээр ноолууран түүхий эдэд экспортын татвар ноогдуулах боломжгүй болсон. Ажлын хэсэг Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрийг хүндэтгэн үзэж стратегийн түүхий эд болох ноолуурын боловсруулалтын түвшинг ахиулах, дотооддоо нэмүү өртөг бүтээх эрхзүйн орчныг бүрдүүлэх боломжит бусад арга замыг судлан, шийдвэрлэхээр ажиллаж байна. /НӨАТ тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Ноолуурын техникийн зохицуулалт, Тусгай зөвшөөрлөөр шийдвэрлэх арга замууд/

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.4-д “мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээд өөрөө бэлтгэсэн буюу тариалсан, үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, өндөг, арьс шир, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон дотооддоо үйлдвэрлэсэн гурилыг дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнийн дүнд нь 10 хувийн албан татвар шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан албан татвар суутган төлөгчийн албан татварыг уг хувиар хасалт хийнэ” гэсэн заалтад “ноос, ноолуур”-ыг нэмж оруулан Улсын Их хурлаар 2019 оны 3 дугаар сард баталсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь ноос, ноолуурын үйлдвэрүүдэд ялангуяа кластераар ажиллаж буй үйлдвэрүүдэд татварын таатай орчныг бий болгож байна.

Манай ажлын хэсэг ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоо, судалгааг боловсруулж Япон, Итали, Герман зэрэг өндөр хөгжилтэй орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. 2018 онд Токио хотноо болсон Монгол-Японы төр хувийн хэвшлийн 9 дүгээр зөвлөлдөх уулзалтад оролцохдоо ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, боловсон хүчин бэлтгэх талаар хамтран ажиллах саналаа танилцуулж улмаар Японы Эдийн засаг, үйлдвэр, худалдааны яамны төлөөлөлтэй хоёр удаагийн уулзалтыг Токио, Улаанбаатар хотноо хийсэн ба Японы тал бидний тавьсан саналыг судалж хариу ирүүлэн, хамтарч ажиллахаар тохиролцсон.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулан салбарын хөгжлийг түргэтгэх зорилгоор Монголын ноос, ноолуурын холбоо болон ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчидтэй салбарт тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцаж “Ноолуур” хөтөлбөрийг эрчимжүүлэх, эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зээлийн нөхцлийг сайжруулах, дотоодын түүхий эд бэлтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн хүчин чадал, түүний ашиглалтыг нэмэгдүүлэх хууль эрхзүйн орчныг сайжруулах бодлого боловсруулах ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А-105 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна.

Ажлын хэсгийг төрийн байгууллагууд, салбарын мэргэжлийн холбоо болон үйлдвэрлэгчдийн төлөөллийг оролцуулан байгууллаа. Ажлын хэсэг ноолууран түүхий эдийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, гүн боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх эрхзүйн зохицуулалтын хүрээнд ноолуурын экспортод техникийн зохицуулалт хийх, стратегийн бүтээгдэхүүнд тавигдах тусгай зөвшөөрлийн асуудлыг судлан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хууль болон холбогдох журамд нийцүүлэн техникийн зохицуулалт боловсруулах, нөлөөллийн үнэлгээ хийх; шинээр байгуулагдах ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах, экспортлоход тусгай зөвшөөрөл олгох асуудлаар

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” болон Улсын Их Хуралд өргөн барихаар мэдүүлсэн “Зөвшөөрлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой бичиг баримтуудыг боловсруулах, ноолуурын үйлдвэрүүдэд аттестатчилал явуулах ажлыг зохион байгуулж байна.

2. Түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, малчид, малчдын хоршоодод зориулсан түүхий эд бэлтгэлийг хэрхэн оновчтой зохион байгуулах, түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалахад малчид үйлдвэрлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар:

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой мах, арьс ширэн түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах чиглэлд өнгөрсөн 2018 оны 11 сарын 01-ээс 12 сарын 15-ны хооронд “Малын гаралтай түүхий эдийн нэмүү өртгийн сүлжээ, мөшгөх тогтолцооны загвар арга хэмжээ”-г хэрэгжүүлж ажилласан. Тус арга хэмжээг ХХААХҮЯ-ны удирдлага дор Улаанбаатар хотын засаг даргын тамгын газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөдөө аж ахуйн бирж ХХК, Монголын арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн холбоо, Монголын махны холбоо, Махны зургаан үйлдвэр, Номин, Е-Март сүлжээ супермаркет, Лавай хүнсний зах, 29-р дунд сургууль зэрэг байгууллагуудыг хамруулан өргөн хүрээнд зохион байгуулж эмийн үлдэгдэлгүй, эрүүл махыг хэрэглэгчид хүргэх, арьс ширэн түүхий эдийг чанартай бэлтгэх зорилгоор хэрэгжүүлсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд өнөөдөр Номин, И-март зэрэг томоохон сүлжээ дэлгүүрүүдээр эрүүл, эмийн үлдэгдэлгүй, чанарын шаардлага хангасан малын махыг нийслэлийн иргэдийн хэрэгцээнд нийлүүлж байгаа ба арьс ширэн түүхий эдийн нядалгааны үеийн болон нядалгааны дараах гэмтлийг 50 хувь бууруулан үндэсний арьс шир гүн боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж ажиллалаа. 2019 оноос эхлэн улс орон даяар энэхүү тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган байна. Мөн Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд Арьс шир, Ноосны урамшууллыг Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын Генетик нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэх хөшүүрэг болгон түүхий эд бэлтгэлийн тогтолцоог хөгжүүлэхээр холбогдох журмыг шинэчилэхээр ажиллаж байна. Ингэснээр мах, ноос болон арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн чанар сайжирч зогсолтгүй ажиллах, ашигт ажиллагаа нэмэгдэх, малчдын орлого нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

Ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийг үйлдвэрийн стандарт шаардлагад нийцүүлэн чанартай бэлтгэх видео сургалтын материалыг бэлтгэж, аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газарт хүргүүлэн, малчид, түүхий эд бэлтгэгчдэд зориулсан сургалтыг явуулж мэдлэгжүүлж байна.

ХХААХҮЯ нь Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөл”, Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих” болон “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил”, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Ноолуурын тогтвортой өртгийн сүлжээ”, Нэгдсэн үндэстний байгууллагын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”, Дэлхийн банкны “Экспортыг дэмжих” төсөл, Европын Холбооны санхүүжилттэй “Монголын Худалдааг Дэмжих - TRAM төсөл, Хил хязгааргүй малын эмч нар ба агрономичид олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй Монголын нэхмэлийн салбарын байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг зэрэг төслүүдийн уялдааг хангаж малын гаралтай түүхий эдийн чанарыг сайжруулах, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх ажлуудыг удирдлагаар ханган хэрэгжүүлж байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн 240 сая төгрөгийн санхүүжилтээр 2018 онд Өвөрхангай аймагт 3, Хөвсгөлд 3, Хэнтийд 1, Баян-Өлгийд 3, нийтдээ 10 агуулахыг ноос, ноолуур, арьс ширэн түүхий эд хадгалах зориулалтаар барьж ашиглалтад оруулсан байна.

Хөдөө аж ахуйн бирж төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани нь малчин гишүүнтэй, загвар хоршоог байгуулах төслийг боловсруулсан ба Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А-113 тоот тушаалаар загвар хоршоо байгуулах төслийг бодлогын түвшинд судалж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2019 оны 2 дугаар улиралд багтаан загвар хоршоог улсын хэмжээнд хөгжүүлэх боломж, санхүүжилтийн талаар дүгнэлт гаргах юм.

Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд малчид, үйлдвэрлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2017 оноос эхлэн орон нутагт ноолуурын дуудлага худалдааг тогтмол зохион байгуулж байгаа ба 2017 оноос 2018 онуудад нийт 58 хоршоонд биржийн итгэмжлэл олгон, арилжаанд оролцуулснаар 120 тонн боловсруулаагүй ноолуур, 58 тонн махыг дотоодын үйлдвэрүүдэд арилжсан ба 2019 онд 100 мянган малыг дотоодын мах боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэхээр гэрээ байгуулаад байна.

Малчид, хоршоо, дотоодын үйлдвэрүүдэд биржээр арилжих бараа, түүхий эдийн захиалгыг авах зорилгоор биржийн арилжааны захиалгын сан /order-mce.mn/-г 2018 онд нэвтрүүлсэн. Энэхүү захиалгын сангаар дамжуулан түүхий эдийн ханшийн мэдээг олон нийтэд цахим орчинд хүргэж, талуудын захиалгыг авч биржийн арилжааг онлайн хэлбэрээр зохион байгуулж байна. Үүний дүнд түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн биржийн арилжаанд оролцох оролцоог нэмэгдүүлж, түүхий эд худалдан авагч үйлдвэрүүдэд өөрийн бизнесээ урьдаас төлөвлөх боломжийг бүрдүүлж өгч байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 12 сарын 20-ны өдрийн 598 тоот тогтоол, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК\*-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 сарын 5-ны өдрийн хурлын 8 дугаар тэмдэглэлийг үндэслэн биржийн өөрийн 2.2 тэрбум төгрөг хөрөнгийн санхүүжилтээр Төв аймгийн Аргалант сумын "Галзуу харын худаг"-т "Улаанбаатар ложистикийн төв"-ийг байгуулж, 2019 оны 12 дугаар сард ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Барилгын болон хашааны ажлын гүйцэтгэгчийг шалгаруулахаар холбогдох хуулийн дагуу тендер зарлан ажиллаж байна. Тус ложистик төвд биржээр арилжаалсан бараа, түүхий эдийг хадгалах, ложистикийн систем болон хяналтын системээр дамжуулан биет бүтээгдэхүүний арилжааг хөнгөвчлөх, дуудлага худалдааг тогтмол зохион байгуулах, санхүүгийн салбарын бусад оролцогчдыг зах зээлд нэвтрүүлэх боломжийг бий болгох ач холбогдолтой юм.

3. Аж ахуй нэгжид өнгөрсөн жил олгосон эргэлтийн хөрөнгийн зээл, түүний хэрэгжилт болон энэ жил үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх талаар:

3.1 Аж ахуй нэгжид өнгөрсөн жил олгосон эргэлтийн хөрөнгийн зээл, түүний хэрэгжилт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Монгол улсын Хөгжлийн банкны хооронд хийсэн "Ноолуур хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий нөхцөл тохирох гэрээ"-ний дагуу Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2018 онд шууд зээлээр 96.6 тэрбум, арилжааны банкуудаар дамжуулан 97.8 тэрбум, нийтдээ 194.4 тэрбум төгрөгийн зээлийг олгосон.

Зээлд хамрагдсан үйлдвэрүүдийн ноолуур бэлтгэлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 1.3 дахин нэмэгдсэн байна. Мөн самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 33.8 хувь, ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадал 28.6 хувь, сүлжих үйлдвэрлэлийн хүчин чадал 42.7 хувиар тус тус өсөж, 1570 ажлын байр шинээр нэмэгджээ. Тухайлбал "Говь" ХХК самнах үйлдвэрлэлийн хүчин чадлаа 21 хувь, сүлжих үйлдвэрлэлээ 6 хувь, оёмол үйлдвэрлэл хүчин чадлаа 50 хувиар, "Гоёо" ХХК ээрэх, сүлжих үйлдвэрийн хүчин чадлаа 3-4 дахин, Могол ноос ХХК оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хүчин чадлаа 8 дахин нэмэгдүүлсэн байна." Говь" ХК жилд 2000 тн ноолуур самнах хүчин чадалтай, анхан шатны үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн суманд байгуулж байна.


Ноолуур боловсруулах салбарын түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 2017 онд 14.1 хувь байсан бол 2018 оны байдлаар 25.0 хувьд хүрсэн байна. Суурь 2014 онтой харьцуулахад 35.8 хувьд хүрсэн.

Үйлдвэрлэлийн хүчин чадлын өсөлтийг салбарын дүнгээр авч үзвэл самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 5.5 хувь, зэрэх үйлдвэрлэлийн хүчин чадал 7.7 хувь, сүлжих үйлдвэрийн хүчин чадал 23.2 хувиар тус тус өссөн.

Гаалийн ерөнхий газрын 2018 оны статистик мэдээгээр Нэхмэлийн салбарын нийт экспорт 409 сая ам.долларт хүрч, өмнөх онтой харьцуулахад 22.2%-иар өссөн байна. Үүнээс ноолуурын салбарын нийт экспорт 390.2 сая ам.долларт хүрч, 2017 онтой харьцуулахад 21.2%-иар өссөн байна.

3.2 Аж ахуй нэгжид олгох эргэлтийн хөрөнгийн зээлийг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх талаар

"Ноолуур" хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 300 хүртэл тэрбум төгрөгийн зээлийг Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэрээр олгохоор тус банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр гарсан ба зээлийг олгож эхлэхэд бэлэн болоод байгаа тухай мэдээллийг тус банкнаас ирүүлсэн.

A rectangular stamp with a double border. Inside, there is a handwritten signature in cursive that reads "Ч.Улаан". To the right of the signature, there is a vertical stamp containing Mongolian text: "МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК" (Development Bank of Mongolia) and "УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК" (Development Bank of Mongolia). The stamp is slightly faded and has some ink bleed-through from the reverse side.

Ч.УЛААН